

**“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2024 ОНЫ 2-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, ТУЗ-н дэргэдэх Эрсдэл болон Аудитын хорооны даргаар ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн тухай хууль, банкны тухай хууль, Богд банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

НЭГ. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуралд оролцсон тоо: 18

Хэлэлцсэн асуудал: 35

2024 оны 2 дугаар улиралд Төлөөлөн удирдах зөвлөлийн 18 хуралд цахимаар болон танхимаар оролцож хурлаар хэлэлцсэн 35 асуудлаар саналаа хурлын тэмдэглэлд товч бичиж, хурлын шийдвэрт тусгуулан ажилласан. Хэлэлцсэн асуудлаар 20 гаруй санал хэлсний 80% нь шийдвэрт туссан болно.

Нидерландын хөгжлийн агентлагийн (FMO) төлөөлөгчидтэй уулзаж банк, Эрсдэлийн болон аудитын хорооны ажлын талаар цаашдын хамтын ажиллагааны асуудлаар ярилцсан нь банкны цаашдын ажилд ач холбогдолтой болсон.

ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН ХОРОО

Нийт хуралдсан тоо: 3

Хэлэлцсэн асуудал: 6

2024 оны 2 дугаар улиралд Эрсдэлийн удирдлагын хороо 3 удаа хуралдаж 6 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

2024 оны 2-р улирал

1	2024.04.15	24/1	1.Богд банкны 2024 оны 1 дүгээр улирлын эрсдэлийн аппетитын гүйцэтгэлийн тайлан 2.Богд банкны 2024 оны 1 дүгээр улирлын МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлан 3.Богд банкны 2024 оны Тогтворжуулах төлөвлөгөөг батлах
2	2024.06.07	24/2	Богд банкны 2024 оны Тогтворжуулах төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай
3	2024.07.04	24/3	1.Богд банкны 2024 оны 2 дугаар улирлын эрсдэлийн аппетитын гүйцэтгэлийн тайлан 2.Богд банкны 2024 оны 2 дугаар улирлын МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлан

ГУРАВ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРОО

Нийт хуралдсан тоо: 1

Хэлэлцсэн асуудал: 2

2024 оны 2 дугаар улиралд Аудитын хороо 1 удаа хуралдаж 2 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

2024 оны 2-р улирал

1	2024.04.15	24/56	1.Богд банкны Дотоод аудитын газрын 2024 оны төлөвлөгөө 2.Банкны 2023 оны тогтворжуулах төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
---	------------	-------	---

Тогтворжуулах төлөвлөгөөнд өөрчлөлт, нэмэлт оруулах шалтгаан, Монгол банкнаас 2024 оны 5-р сарын 13-нд ирсэн А-16/324 тоотын дагуу авсан ба авах арга хэмжээний талаар нэлээд тодорхой хэлэлцэж, төлөвлөгөөг шинэчилсэн.

**“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ
ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2024 ОНЫ 2-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”****ТАВ .СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ**

Мөн хугацаанд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 3 удаагийн хэлцэлд оролцож өөрийн саналыг өгч, сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухайн асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэж ажилласан.

2024 оны 2-р улирал			
1	2024.04.11	24/54	Бодь цамхаг ХХК-д зээл олгох тухай
2	2024.05.08	24/66	Л.Болдхуягт зээл олгох тухай
3	2024.06.07	24/79	М.Алтанбаганад машин худалдах тухай

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ХУВЬД:

Богд банк ХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу банкны засаглалыг хэрэгжүүлэн хангалттай сайн ажиллаж байна. Удирдлагын баг, ТУЗ-ийн гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хооронд харилцааны үл ойлголцол байхгүй, банкны шийдвэр гаргалт нэг албан тушаалтны хэт төвлөрөлгүйгээр зохих журмын дагуу явагдаж байна.

Заавал мөрдөх ёстой аливаа хууль, дүрэм журмыг зөрчсөн болон харилцагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр, үйлдэл банкны үйл ажиллагаанд гараагүй болно гэж үзнэ.

Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох чөлөөлөх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2024 оны 2 улирлын товч тайланг бэлдэн хүргүүлэв.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2024.07.08

Э.Бямбажав.